

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт


НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН НӨХӨН ҮРЖИХҮЙ,
ЭРЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.ОРОЛЗОДМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
			1	2	3	4	5

Зорилт 1. Нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн бодлого боловсруулах


1.	"Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай" журмыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан байна	Эрүүл мэндийн сайдын 2017 оны A/399 дүгээр тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан байна	<p>"Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын A/107 дугаар тушаалаар 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, ажлын хэсгийн хурлыг 5 удаа хийсэн. ЭХЭМҮТ, АШУҮИС, Нийслэлийн ЭМГ, 6 дүүргийн ЭМТ-ийн НЭМОД, Өрхийн менежер, ХЕЗ, өсвөр үеийн эмч, ΘЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, Азийн хөгжлийн банк, ТББ-уудын төлөөлөл болох нийт 41 хүний бүрэлдэхүүнтэй уулзалт, хэлэлцүүлгийг 2024.05.10-ны өдөр зохион байгуулж журмын төсөлд санал авсан. Журмын төслийг нэгтгэн ажлын хэсгээр 2024.09.20-ны өдөр хэлэлцүүлэн, эцэслэн газрын дарга нараас санал авч нэгтгэн, Эрүүл мэндийн сайдад хянагдаж байна.</p>	01.01 12.01	70
2.	Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайд,	Эрүүл мэнд, Боловсролын сайдын	Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны хамтарсан "Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг	01.20 12.01	70



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин						
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа		
			1	2	3	4	5		
	сайдын хамтарсан “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” журмыг шинэчлэн батлуулах	батлагдсан байна	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 сарын 27 - ны A/480, A/739 тоот тушаал	хамтарсан тушаал батлагдсан байна	зохион байгуулах тухай” А/480, А/739 дүгээр тушаалыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/44 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа хуралдуулан хамтарсан тушаалын төслийг боловсруулан газрын дарга нараас санал авч нэгтгэн, Эрүүл мэндийн сайдад хянагдаж байна. Боловсролын яамны газрын дарга нараар хянагдан, Боловсролын сайд 2024.10.15-ны өдөр тушаалын төсөл дээр зурсан. Төр болон хувийн хэвшлийн 23 их, дээд сургуулийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх боломжгүй 998 оюутан, суралцагчдын судалгааг БЯ-тай хамтран гаргаж ЭМДЕГ-т 2024.03.11-ний өдрийн 6/1005 дугаар албан бичгээр хүргүүлж, суралцагч бүрээр он, оноор тооцоолол гаргуулсан. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөд нийт 45 сая төгрөг шаардлагатай байгааг тооцоолон Эрүүл мэндийн сайдын 2024.03.21-ний өдрийн “Төсөв баталж, санхүүжилт олгох тухай” А/128 дугаар тушаалыг батлуулж, холбогдох санхүүжилтийг Эрүүл мэндийн сайдын багцаас гаргахаар шийдвэрлэсэн. БЯ-нд 2024.04.02-ны өдөр 2/2304 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн сайдын А/128 дугаар тушаалыг хүргүүлсэн.				
3.	“Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын	Эрүүл мэндийн сайдын	Эрүүл мэндийн сайдын А/445 дугаар тушаалаар “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам”-ыг	01.01 09.01	100		




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин						
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
					1	2	3	4	5
	хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам"-ыг шинэчлэн, боловсруулж батлуулах	батлагдсан байна.	2019 оны A/563 дугаар тушаал	тушаал батлагдсан байна, хэрэгжилт 60%-д хүрсэн байна	шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийг байгуулан нийт 9 удаа хуралдуулсан. Журмын төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалтыг ЭХЭМҮТ, ЭМХТ, Нийслэлийн ЭМГ, 9 дүүргийн ЭМТ-ийн НЭМОД, Өрхийн менежер, НҮЕЗ эмч нар болон ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүд, Мари Стопс эмнэлгийн удирдах албан тушаалтан болох 60 хүний төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн мэдээллийн сан үүсгэж, тасралтгүй хяналт үнэлгээ хийж тусlamж үйлчилгээг тогтвожуулах нь чухал байсан учир дээрх тушаалыг шинэчлэн, боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2024.01.09-ний өдөр "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журам шинэчлэн батлах тухай" А/11 дүгээр тушаал батлагдсан. Уг тушаалыг 2024.01.12-ны өдрийн 6/158 дугаар албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын А/11 дүгээр тушаал, шийдвэр танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт оролцох тухай 5/2719 тоот албан бичгийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн 2024.06.20-ны өдөр ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭНЭҮТ-II, НЭМГ, Амаржих газар, дүүргийн ЭМТ, Өрхийн ЭМТ-үүдийн удирдлага болон холбогдох эмч, мэргэжилтэн нар болох нийт 50 хүн оролцсон уулзалт, хэлэлцүүлгийг 2024.06.26-ны өдөр хийсэн. Мөн 21 аймгийн удирдах болон холбогдох албан хаагчдыг оролцуулсан цахим уулзалт				




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин							
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь		
			1	2	3	4	5	6	7	
						<p>хэлэлцүүлэг зохион байгуулах тухай 6/3724 тоот албан бичгийг 2024.09.12-ны өдөр аймгийн ЭМГ-ын дарга нарт явуулан нийт 100 хүн оролцосон цахим уулзалт, хэлэлцүүлгийг 2024.09.17-ны өдөр хийсэн.</p> <p>Тушаалын хэрэгжилтийн үр дүн: Одоогийн байдлаар ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албаны жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тандалт мэдээллийн нэгдсэн сан бүхий цахим програмд 740 эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл орж, 35,335 хувь хүний талаарх мэдээлэл бүртгэгдсэн байна.</p>				

Зорилт 2. Нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах


1.	Арга хэмжээ 2.1 ЗГУАХ 2.1.1.3 МУХТЖУЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.8 “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх	ЗГУАХ-ийн хүрэх түвшин	Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 80,1 хувьтай байна. Үүнд:	01.01 12.30	100
					<ul style="list-style-type: none"> ➤ 1-р Зорилт 69% ➤ 2-р Зорилт 89% ➤ 3-р Зорилт 81,5% ➤ 4-р Зорилт 94% ➤ 5-р Зорилт 67,1% байна. <p>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:</p> <p>Улсын хэмжээнд 2024 оны 12 сарын 03-ны байдлаар 52514 эх төрж, 52830 хүүхэд амьд төрсөн байна. Амьгуй төрөлтийн түвшин 5.1 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд 11 эх эндэж,</p>		




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	
			1	2	3	4	5	
					эхийн эндэгдлийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна. Харин тав хүртэлх насы 809 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 15.3 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн бол нэг хүртэлх насы 645 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 12.2 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна. Нярайн эндэгдэл 403 нярай эндэж, эндэгдлийн түвшин 7.6 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.	6	7	
					Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.			
2.	Арга хэмжээ 2.2 ЗГУАХ 2.1.1.7 МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.7 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлэх.	ЗГУАХ-ийн хүрэх түвшин	Арга хэмжээний хэрэгжилт 50.6 хувьд хүрсэн	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах эрэгтэйчүүдийн хувь 70-д хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 75,6 хувтай байна. Үүнд: ➤ 1-р Зорилт 65.8% ➤ 2-р Зорилт 89% ➤ 3-р Зорилт 84.8% ➤ 4-р Зорилт 62.6% байна. Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн шалгуур үзүүлэлт: 2022.05.01-ний өдрөөс 2024.11.14-ний өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1,549,479 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 45.8	01.01 12.30	100	




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
			1	2	3	4	5
					хувийг эзэлж байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 676,324 буюу 43.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь зорилтолт түвшний 62.8 хувийг эзэлж байна.		
					2024 оны байдлаар улсын хэмжээнд төрийн 23 эрүүл мэндийн байгууллагад урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагаас нийслэлд 12, аймаг 11 байна.		
					2023-2024 оны хичээлийн жилд Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, мэс засал судлал төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр 8 эмч суралцахаас 8 суралцаж, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Хэнтий зэрэг 7 аймгаас 7 их эмч Төрийн сангийн зардлаар, үлдсэн 1 нь хувийн зардлаар суралцаж байна.		
					Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.		
3.	Арга хэмжээ 2.3 Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяныг зохион байгуулах	Батлагдсан удирдамж, хөтөлбөр	2023 онд 3 сарын үйл ажиллагаа зохион байгуулсан	Үйл ажиллагаа 80% хийгдсэн байна	Оюутан, суралцагчдын эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, аяны хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөг 2024.09.25-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан ЭМДЕГ, НЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ болон дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд үйл ажиллагааг зохион байгуулах тухай 2024.09.27-ны өдрийн 6/3951 тоот албан бичиг хүргүүлсэн.	09.01 12.01	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					5	6		
1	2	3	4					
					<p>Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг 2024.10.01-ний өдөр НЭМБГ-ын даргаар батлуулан, хуваарийн дагуу эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн ажил, оюутан, суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 28-ны хооронд 36.684 оюутан, 50.380 удаагийн гүйлгээгээр 561.982.859 сая төгрөгийн шимтгэл төлсөн байна. Нийт 83 контент бэлтгэснээс инфографик 56, цаг үе үйл явдлын мэдээ мэдээлэл 10, хөдөлгөөнт постер 10, рийл 7-ыг бэлтгэн түгээсэн нь 275.032 хүнд хүрч 2.481 удаа хуваалцсан байна. МУБИС, МУБИС, ШУТИС, Дотоод хэргийн их сургуулийн оюутан, залуусын дунд “Нөхөн үржихүй-Гэр бүл төлөвлөлт”, “БЗДХ-өөс Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, “Архи, тамхины хор уршиг”, “Эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдол” сэдвүүдээр эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 4139 оюутан залуус хамрагдсан. 31 их дээд сургуулийн нийт 3350 оюутан, залуучууд эрт илрүүлэгт хамрагдаж, 316 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь Эрүүл мэндийн сайдын багцаас төлсөн 998 оюутан, суралцагчдаас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэгт одоогийн байдлаар 307 оюутан хамрагдаад байна. 			




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
	1	2	3	4	5	6	7
4.	Арга хэмжээ 2.4 Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт Хүний папиллома вирусийн өндөр эрсдэлт 14 хэв шинжийг илрүүлэх шинжилгээнд суурилсан аргыг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Сургалт, сурталчилгааны ажил	ЭМС-ын 2020 оны удирдамж	Сургалт – 1 сурталчилгааны ажил – 2 тус тус хийгдсэн байна	"Хүний папиллома вирусийн халдвартын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны 2024-2025 оны төлөвлөгөө"-г Эрүүл мэндийн сайдаар 2024.03.26-ны өдөр батлуулсан. Уг төлөвлөгөөний 5 дугаар зорилт болох "Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт ХПВ илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэх" хүрээнд 5 үйл ажиллагааг хийхээр төлөвлөн оруулсан. 2024.05.23-ны өдөр "Хүний папиллома вирусийн халдвартын эсрэг вакцин нэвтрүүлэх бэлэн байдал хангах сургалт", "Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт ХПВ илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэх" сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 120 гаруй эмч, мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан. Аймаг, нийслэл, ТББ-уудад "Хүний папиллома вирусийн халдвартын эсрэг вакцин нэвтрүүлэх бэлэн байдал хангах сургалт", "Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт ХПВ илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэх" сэдвээр сургалт зохион байгуулахтай холбоотой 2024.11.05 өдрийн 6/4531, 2024.11.21 өдрийн 2/4865 тоот албан бичгүүд явуулан, сургалтын хөтөлбөрийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Үүнд: 1. 2024 оны 11 дүгээр сарын 12, 13, 14-ний өдрүүдэд Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд болон ТББ-уудын Эх баригч, эмэгтэйчүүд, өсвөр үеийн эмч, баригч бага эмч, дүүргийн ЭМТ-ийн хүүхдийн болон нөхөн үржихүйн зохицуулагч нар, ӨЭМТ-ийн эмч нар, залуучуудын төвийн нийгмийн ажилтан, насан	01.01 12.01	100




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
			1	2	3	4	5
					<p>туршийн боловсролын төвийн зөвлөгч нар нийт 110 хүнд сургалт хийсэн.</p> <p>2. 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр мөн дээр сэдвээр 21 аймгийн ЭМГ, БОЭТ, нэгдсэн аймаг, Өрх, сумын ЭМТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч, өсвөр үеийн эмч, эх, баригч бага эмч наарт цахим сургалтыг нийт 500 хүнд хийсэн.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2024.07.19-ний өдрийн Хавдартай тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай А/331 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2024.08.15-ны өдрийн Умайн хүзүүний хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, хавдартай тэмцэх хөтөлбөрт тусгах техникийн ажлын хэсэг байгуулах тухай А/355 дугаар тушаалын ажлын хэсэгт орж ажиллан ажлын хэсгийн 5 удаагийн хуралд оролцсон. Одоогийн байдлаар умайн хүзүүний ХПВ болон эсийн шинжилгээнд 30 ба 40 насанд эмэгтэйчүүдийг хамруулахаар алгоритм гараад байна.</p> <p>НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины ач холбогдол, умайн хүзүүний ХПВ болон эсийн шинжилгээний ач холбогдол, уг вирусээр үүсгэгдэг хавдруудын талаарх олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны агуулгыг бүлэг бүрт зориулан бэлгэн гаргаж 195,000 ширхэг брошюр хэвлэн гаргаж эмч мэргэжилтэн болон иргэдэд түгээгээд байна.</p>	6	7



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					5	6		
1	2	3	4		5	6	7	
					ЭМЯ, ХӨСҮТ, ХСҮТ, НЭМҮТ, ЭХЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ, ТББ-үүд хамтран охид, бүсгүйчүүдийн уг хорт хавдрын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, эрт илрүүлэг шинжилгээ болон вакцинжуулалтын талаар мэдээлэл өгөх, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг подкаст хийн цахим хуудсанд байршуулсан. (Хандалт - 1143196, Хуваалцсан - 2383)			
5.	Арга хэмжээ 2.5 Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэрэг, сонсогчдыг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Батлагдсан төлөвлөгөө	Батлан хамгаалах, Эрүүл мэндийн Дэд сайдын хамтарсан ажлын удирдамж батлуулсан	Төлөвлөгөөний хэрэгжилт 50%-д хүрсэн байна.	Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх 9 зорилт, 43 үйл ажиллагаа бүхий цаглавар үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн дэд сайдаар батлуулсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх тухай” А/150 дугаар тушаалын дагуу Цэргийн төв эмнэлэг эрт илрүүлэг, үзлэгийг цэрэг, армийн албан хаагч, цэрэг, сонсогчдод болон эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулах хуваарь гарсан. Цэргийн төв эмнэлэг нь суурин болон хөдөлгөөнт амбулатори гэсэн 2 байдлаар эрт илрүүлэгт оролцсон. Үүнд: ➤ Суурин үзлэгийг Цэргийн төв эмнэлгийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д Улаанбаатар хот болон хотын ойролцоо Зэвсэгт Хүчний анги салбарт алба хааж буй	01.01 12.01	100	




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
	1	2	3	4	5	6	7				
					бүрэлдэхүүн, Баянзүрх дүүрэгт байрлах Дотоод хэргийн их сургуулийн оюутан, суралцагчдад эрт илрүүлэг үзлэг хийн нийт 6244 иргэнийг хамруулсан байна. ➤ Хөдөлгөөнт амбулаторийн үзлэгийг хөдөө орон нутагт байрлах Зэвсэгт Хүчний анги салбарт алба хааж буй бүрэлдэхүүн тэдгээрийн ар гэрийн гишүүд, тэтгэвэрт чөлөөнд байгаа бүрэлдэхүүн болон тухайн анги салбар байрлаж байгаа сум орон нутгийн иргэдэд үзлэг шинжилгээг хийж 2024 онд нийт 7554 км замыг туулж, 4404 иргэнийг үзлэг оношилгоонд хамруулсан байна.						
6.	Арга хэмжээ 2.6 Цэвэршилтийн үеийн амьдралын хэв маягийн онцлог, анхаарах асуудлын талаарх сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалт, сурталчилгаан ы ажил	Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/760 дугаар тушаалын 4.13 дахь заалт	Сургалт – 1 сурталчилгаан ы ажил -2 хийгдсэн байна	AШҮҮИС-ийн Эх, барих эмэгтэйчүүдийн танхим, ЭХЭМҮТ-тэй хамран нийслэлийн 9 дүүргийн нөхөн үржихүйн зохицуулагч, эх барих эмэгтэйчүүдийн эмч наарт “Цэвэршилтийн үеийн хам, шинж” сэдвээр 2024.03.06-ны өдөр сургалт цахимаар 100 хүнд зохион байгуулсан. Мөн Эх, барих эмэгтэйчүүдийн танхимтай хамtran 21 аймгийн эх, барих эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтэнг хамруулсан цахим сургалтыг 2024.09.06-ны өдөр 500 хүнийг хамруулан хийсэн. Цэвэршилтийн үеийг хэрхэн даван туулах вэ? сэдвийн хүрээнд 2 төрлийн инфографикийг цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээсэн. (Хандалтын тоо-23825, хуваалцсан тоо-177) Азийн хөгжлийн банкны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн	01.01 12.01	100				




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
	1	2	3	4	5	6	7
					хүрээнд 2024 онд ЭМЯ-ны шаардлагатай контентуудыг хийхээр тусгагдсаны дагуу “Цэвэршилтийн үеийн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлт” 1 инфографик, 1 рийлийн агуулгыг боловсруулан эх бэлтгэн, түгээхэд бэлэн болгосон.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					1	2	3	4
1.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх ажил зохион байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан байна	-	Тушаал хэрэгжилтийг ханган ажилласан байна	Халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан шинжээчийн ажлын байрыг 2024.01.01 – 08.15 хүртэл орлон ажиллаж байх хугацаанд:	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар “Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх тусгай зориулалтын автомашиныг ашиглах түр журам” баталсан. Явуулын клиникиг ашиглан орон нутагт УНТЭ, УХТЭ, УГТЭ, Цэргийн төв эмнэлгийн эмч нараар ахлуулсан төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй явуулын багууд 2024.04.08-ны өдрөөс 07.01-нийн өдрийн хооронд “Нүүдлийн эмнэлэг” бүхий эмнэлгийн тоног, төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон явуулын автомашинаар 21 аймаг, 114 сумын нийт 18,707 хүнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж ажилласан байна.	01.01 09.01	100




Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур чигүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь		
						6	7		
1	2	3	4	5	6	7			
					<p>“Нүүдлийн эмнэлэг” бүхий явуулын багийг орон нутагт ажиллахад мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах үүрэг бүхий шуурхай багийг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр байгуулан ажилласан.</p> <p>Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024.01.29-ний өдрийн А/36 дугаар тушаалаар, Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх 9 зорилт, 43 үйл ажиллагаа бүхий цаглавар үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын дэд хэсэг байгуулах тухай удирдамжийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тус тус батлуулсан.</p> <p>Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх чиглэлээр яамны харьяа эрүүл мэндийг дэмжих төвтэй эмнэлгүүд, нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт 03, 09 дүгээр сард хийж ажиллах удирдамж болон хуваарийг батлуулан. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх, Багахангай дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд ажилласан.</p> <p>Аймгийн Засаг дарга, ЭМГ-ын дарга нарт 2024.04.04-ний өдөр Эрүүл мэндийн сайдын “Эрт илрүүлгийг нутаг дэвсгэрийн хүрээнд эрчимжүүлэх, нүүдлийн эмнэлгийг ажиллуулахад бэлтгэл хангах тухай” 1а/1367 тоот албан бичиг явуулсан.</p>				
2.	Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний	Засгийн газрын тогтоолоор зөвлөлийн	-	Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний	Халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан шинжээчийн ажлын байрыг 2024.01.01 – 08.15 хүртэл орлон ажиллаж байх хугацаанд:	04.01	100		




Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур чигүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь		
1	2	3	4	5	6	7			
	зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлаж ажиллах журмын төслийг боловсруулах	бүрэлдэхүүн батлагдсан байна		зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдаж, ажиллах журмын төсөл боловсруулагдсан байна	"Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/149 дүгээр тушаалаар батлагдсан. Ажлын хэсэг 4 удаа хуралдан Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн болон зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулан 2024.04.26-ны өдөр дотоод меморандумаар санал авч нэгтгэн 06.04-ний өдөр Эрүүл мэндийн яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн саналыг нэгтгэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024.08.07-ны өдрийн "Засгийн газрын Үндэсний хороо, комисс, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 21 дүгээр тогтоолын 18 дугаар хавсралтаар "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдаар ахлуулан 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлуулсан.	09.01			
3.	Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хорооны үйл ажиллагаа	Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хийгдсэн байна	-	Төлөвлөгөөний биелэлт 50% дээш хэрэгжсэн байна	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.08-ны өдрийн А/56 дугаар тушаалаар Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. Тус хороонд нарийн бичгийн даргаар ажиллаж 2024 онд 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусган Дэд хорооны даргаар батлуулсан. Хэрэгжилт 75%-тай байна	01.01 12.30	100		

158




Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур чүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь			
					1	2	3	4	5	6	7
					Ёс зүйн дэд хороо байгуулагдсан цагаас хойш нийт 11 удаа хуралдаж, 10 асуудал хэлэлцсэн. Эрүүл мэндийн яамны албан хаагчдаас байгууллагын соёлын судалгаа авч, үр дүнг нэгтгэсэн. Судалгаанд нийт 60 албан хаагч оролцсон нь тус яамны нийт албан хаагчдын 71%-ийг эзэлж байгаа тул төлөөлөх чадвартай гэж үзсэн. МУ-ын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" 109 дүгээр тогтоолоор 11.07-ны өдөр Ёс зүйн дэд хорооны дарга Л.Лувсан яамны нийт албан хаагчдад мэдээлэл хийсэн. (хамрагдалт 94%). Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хороонд 2024 оны 12 дугаар сарын байдлаар ёс зүйн зөрчилтэй холбоотой 6 гомдол, мэдээлэл ирсэн. Үүнээс 4 асуудлыг хянан шалгаж шийдвэрлэсэн. Үүнээс 2 гомдол, мэдээлэл хянан шалгах ажиллагаа үргэлжилж байна. Ёс зүйн дэд хорооны нарийн бичгээр ажиллах хугацаанд 10.01-ний өдөр Архивын ерөнхий газарт 7/3988, 11.04-ны өдөр Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт 7/4483, 11.08-ны өдөр Ёс зүйн хорооны даргад 7/4601, 11.11-ний өдөр ТНБД-д 7/4604, 11.11-ний өдөр ХШУДАГ-ын даргад 7/4603, 12.06-ны өдөр УНТЭ-ийн ерөнхий захиралд 7/5163 албан тоот боловсруулан тус тус явуулсан. Улирал болгон Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдол, мэдээллийн талаар тоо тайлан болон хорооны дүгнэлтийг хавсарган Ёс зүйн хороонд 2 удаа хүргүүлсэн.						
4.	Эрүүл мэнпийн яамны “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагаа	Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хийгдсэн байна		Төлөвлөгөөний биелэлт 50% дээш	ТНБД-ын 2023.08.31-ний өдрийн А/110 дугаар тушаалаар 8 гишүүнтэй “Эцэг эхийн зөвлөл” байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар ажиллан 2023-2024 онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг зөвлөлийн		01.01 12.30	100	100		



Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь		
					1	2	3	4	5	6
				хэрэгжсэн байна	даргаар батлуулан, үйл ажиллагаа явуулж байна. Хэрэгжилт 90%-тай байна. 2024 онд байгууллагынхаа албан хаагч, тэдгээрийн гэр бүл, үр хүүхдүүдэд Чингис хаан Үндэсний музейг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 85 том хүн, 98 хүүхэд үзэж сонирхлоо. Тус байгууллагаас гаргасан боловсролын хөтөлбөрт нийт 98 хүүхэд оролцов. Боловсролын хөтөлбөрт тусгагдсан “Хоригийн өрөмтэй ваарыг урлах нь” ваар урлалын хөтөлбөрт 50 хүүхэд, “Хүннүгийн бэлгэт гөрөөс” магнит хийх хөтөлбөрт 26 хүүхэд, “Шороон бумбагарын бунхны хамгаалагч домгийн амьтан зурах” уран зургийн хөтөлбөрт 22 хүүхэд тус тус хамрагдсан. 2024 оны 04 дүгээр сард Эрүүл шүд урьдчилан сэргийлэх үзлэгийг Нийслэлийн шүд эрүү нүүрний төвтэй хамтран зохион байгуулж, нийт 65 хүүхдэд шүдний тусламж үйлчилгээ (шүдний зөвлөгөө, шүд ломбодох, фтор түрхэх) үзүүлсэн.					

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7		
1.	Арга хэмжээ 2.1. Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг,	Сургалтад хамрагдсан байх	1 сургалтад хамрагдсан	Богино хугацааны сургалтад сурсан байна.	Япон Улсын Нагоя хотын Айчи мужид байрлах Жайка Чубу төвөөс зохион байгуулсан "Мэдлэгийг хамтран бүтээх хөтөлбөр"-ийн хүрээнд	01.01 12.01	100	



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
	мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах				"Амьдралын хэв маягтай холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт богино хугацааны сургалтад 2024.02.12-оос 03.01-нийн өдрүүдэд ЖАЙКА-Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр суралцсан. Богино хугацааны сургалтад амжилттай сурсан сертификаттай төгссөн.		
2.	Арга хэмжээ 2.2. Удирдлагын академийн төрийн албан хаагчийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Төрийн албан анх томилогдсон мэргэшүүлэх багц цагийн сургалтад хамрагдсан	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2024 оны 03 дугаар сарын 19-өөс 06 дугаар сарын 14-ний өдрүүдэд хамрагдан нийт 11 багц цагийг биелүүлэн суралцасан. Удирдлдагын академийн захирлын 06 дугаар сарын 14-ний өдрийн A/420 тоот тушаалаар сертификат авсан. /Сертификатын дугаар R2243/	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2024 оны 03 дугаар сарын 19-өөс 06 дугаар сарын 14-ний өдрүүдэд хамрагдан нийт 11 багц цагийг биелүүлэн суралцасан. Удирдлдагын академийн захирлын 06 дугаар сарын 14-ний өдрийн A/420 тоот тушаалаар сертификат авсан. /Сертификатын дугаар R2243/	03.01 12.01	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нөхөн үржихүй, эрэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Оролзодмаа /  /

2024.12.05



